



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/186

Сүхбаатар сум

### Малын хагас жилийн түүвэр судалгаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.1 "г", Статистикийн тухай хуулийн 18.1, 20.2 дах заалт, Үндэсний Статистикийн хорооны даргын 2019-оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/421 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны хагас жилийн малын түүвэр судалгааг аймгийн хэмжээнд 06 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Түүвэр судалгааг удирдан зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Гүндэгмаа

- Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Х.Батбаатар

- Аймгийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Х.Мөнхтөр

- Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Х.Цэнгэлсайхан

- Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга

Б.Пүрэвдсрж

- Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны мэргэжилтэн

- Сумдын Засаг дарга нар

3. Малын хагас жилийн түүвэр судалгааг зохион байгуулах сумын салбар ажлын хэсгийг томилон ажиллуулж, 2019 оны 06 дугаар сарын 14-ний дотор судалгааны дүнг аймгийн Статистикийн хэлтэст хүлээлгэн өгөхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. 2018 оны хагас жилийн малын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн мэдээлэл нь жилийн эцсийн мал тооллогын мэдээллээс зөрүүтэй байх тохиолдол гарч байсан тул энэ удаагийн малын түүвэр судалгааны мэдээллийн чанарт онцгой анхаарч ажиллахыг сумдын ажлын хэсэгт даалгасугай.

My Doc Zahiramj

5.Аймгийн хэмжээнд түүвэр судалгааны бэлтгэл ажлыг сайтар хангаж, чанартай зохион байгуулах, ажлын үе шат бүрд хяналт тавьж, судалгааны дүнг хугацаанд нь гаргаж Үндэсний Статистикийн хороонд хүргүүлэхийг аймгийн Статистикийн хэлтсийн дарга /Д.Гүндэгмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ